

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: g.gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Г УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА ТӨЧҮЛТЭМЖАМЦ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.21 № 38

танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн хэмжээнд нийт 34,500 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2023 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар 24,834 иргэнд олгож хэрэгжилт 71.90 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 104 дүгээр шийдвэрээр 424,962.0 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг шилжүүлэн авч, тус хэлтэс байртай болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 хөтөлбөр, 4 зорилт, 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 35 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж

. 07020101

гүйцэтгэлийн төлөвлөөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 96.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	47952.6	31,300.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	242,500.3	629,815.3
Нийт хөрөнгийн дүн	290,452.9	661,115.5
Нийт өр төлбөрийн дүн	328.5	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	290,124.3	
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	290,452.9	661,115.4
Үйл ажиллагааны орлогын дүн	596,602.3	1,411,537.6
Үйл ажиллагааны зардлын дүн	637,067.5	1,021,121.4
Үйл ажиллагааны үр дүн	-40,465.5	390,416.3
Үйл ажиллагааны бус үр дүн	14,000.0	19,425.1
Үйл ажиллагааны нийт үр дүн	-54,465.5	370,991.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,492.9	290,452.9
Тайлант оны үр дүн	252,631.4	370,991.1
Эцсийн үлдэгдэл	290,452.9	661,115.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	639,439.9	1,040,549.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	638,151.4	1,040,178.5
Үйл ажиллагааны ЦМГ	1,288.5	370.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	960.0	699.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-960.0	-699.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	328.5	-328.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	328.5	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	946,513.3	944,715.7
Урсгал зардал	946,513.3	944,715.7
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	945,513.3	944,715.7
Улсын төсвөөс санхүүжих	946,513.3	944,715.7
Орон нутгийн төсвөөс санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчил илрээгүй байна.

Говь-Алтай аймгийн
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСЭЙН
ГАЗАР